



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/442


Ховд

Сумдын Засаг дарга нарын цалингийн  
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтад заасны дагуу сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарын цалингийн хэмжээг шинэчлэн баталж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Бусад нэмэгдлийг холбогдох хууль, журмын дагуу тооцож, хавсралтаар батлагдсан цалингийн хэмжээг цалингийн сан, батлагдсан төсөвт багтаан олгохыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.
5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/97 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 1963  
Zah A/442 Ba

Аймгийн Засаг даргын 2023 оны  
08 дугаар сарын 10-ны өдрийн  
А/442 дугаар захирамжийн хавсралт



СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Цалингийн хэмжээ	Онцгой нөхцөлийн нэмэгдэл (хувиар)
1	2	3	4
1	Сумын Засаг дарга	1,950,000	30

-оОо-